

**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 52 тоот тогтоол**

## **МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙГ ХАМТРАН АШИГЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах А ангиллын тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчид нь (цаашид Үйлчилгээ эрхлэгч гэх) бусад үйлчилгээ эрхлэгчидтэй мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг хамтран ашиглах үед үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг хамтран ашиглах нь үр ашиггүй хөрөнгө оруулалтыг багасгаж, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой байна.
- 1.3 Энэхүү журмыг мөрдөхдөө Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Монгол Улсын Мэдээлэл, холбооны сүлжээний зохицуулалтын баримт бичиг (цаашид Зохицуулалтын баримт бичиг гэх) эдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зохицуулалтын баримт бичиг болон Харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй Монгол Улсын үндэсний стандартуудыг мөрдлөг болгоно.
- 1.4 Энэхүү журамд Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулинд болон зохицуулалтын баримт бичигт зааснаас бусад дараахи нэр томъёоны тодорхойлолтыг хэрэглэнэ.
- 1.4.1 “Сүлжээний элемент” гэж төлбөр тооцоог тусад нь тооцох боломжтой, байр талбай, цамхаг, техник тоног төхөөрөмж, агааржуулалтын систем, галын дохиоллын систем, зай тэжээл зэрэг сүлжээний бие даасан нэг хэсгийг хэлнэ.
- 1.4.2 “Нөөц” гэж үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг тасалдалгүйгээр найдвартай хүргэх зорилгоор мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтэц түүний элементийн тодорхой хэмжээний нөөцөлсөн хэсгийг ойлгоно.

### **ХОЁР. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- 2.1 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн эзэмшлийн сүлжээ, барилга байгууламж, байр талбай, техник тоног төхөөрөмж зэрэг дэд бүтцээ бусад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ашиглах эрхтэй.
- 2.2 Энэ журмын 2.1-т заасан эрхээ үйлчилгээ эрхлэгч эдлэхдээ дэд бүтцийг хамтран ашиглах сонирхолтой үйлчилгээ эрхлэгчтэй үл ялгаварласан, ижил нөхцөлтэй

Монгол Улсын холбогдох хууль, журманд нийцүүлсэн гэрээг харилцан тохиролцон байгуулж хамтран ажиллана.

- 2.3 Гэрээндээ энэхүү журмаар зохицуулаагүй бусад асуудлыг хоёр тал харилцан тохиролцож тусгаж болно.
- 2.4 Талууд өөр хоорондоо байгуулсан гэрээний нууцыг харилцан хадгалах үүрэгтэй бөгөөд аль нэг талын бизнесийн нууцыг бусдад задруулахыг хориглоно.
- 2.5 Үйлчилгээ эрхлэгч нь нөөц гэж тодорхойлсноос бусад өөрийн эзэмшлийн сүлжээ, барилга байгууламж, байр талбай, техник тоног төхөөрөмжөө бусад үйлчилгээ эрхлэгчдэд түрээслүүлэх, хамтран ашиглахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй.
- 2.5.1 Үйлчилгээ эрхлэгч нь Монгол улсын Харилцаа холбооны тухай хуулийн 23.1-д заасны дагуу өөрийн сүлжээ, дэд бүтцийг ашиглуулна.
- 2.5.2 Үйлчилгээ эрхлэгч нь тухайн зах зээлийн давамгайлалч тохиолдолд өөрийн эзэмшлийн сүлжээ, дэд бүтцийг бусад үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ашиглах боломж бололцоог бүрэн хангаж ажиллана.
- 2.6 Үйлчилгээ эрхлэгч нь сүлжээ, дэд бүтцийг хамтран ашиглах техникийн нөхцөл шаардлага, үнэ тариф, гэрээ хийх үйл явцын талаархи мэдээллийг бусдад нээлттэй байлгаж, өөрийн цахим хуудас болон танилцуулгадаа хэвлэн нийтэлнэ.
- 2.7 Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг бусдад ашиглуулахдаа ялгаваргүй ижил нөхцөлөөр хандаж, эхэнд нь хүсэлт гаргасанд эхэлж үйлчлэх зарчмыг баримтална.
- 2.8 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн сүлжээний элемент, барилга байгууламж, байр талбайн байршил, техник тоног төхөөрөмжийн багтаамж, техникийн нөхцөл, түрээсийн төлбөр, үзүүлэх гэж буй үйлчилгээ болон бусад холбогдох мэдээллийг хүсэлт гаргасан бусад талд гаргаж өгөх үүрэгтэй. Мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 14 өдрийн дотор гаргаж өгнө.
- 2.9 Энэхүү журмын 2.8-д заасан мэдээллийг нууц гэж үзвэл холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн гаргасан өөрийн байгууллагын нууцын журмыг мөрдөхийг мэдээлэл авах хүсэлт гаргасан этгээдээс үйлчилгээ эрхлэгч нь шаардах эрхтэй.
- 2.10 Үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу Зохицуулах хороо болон бусад хуулиар мэдээлэл авах эрхтэй төрийн байгууллагад шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.
- 2.11 Энэ журмын 2.10-д заасан мэдээллийг нуун дарагдуулах, хуурамч мэдээлэл гаргаж өгөх, гаргаж өгөхгүй удах зэрэг хууль бус үйлдэл гаргахыг хориглоно.

- 2.12 Үйлчилгээ эрхлэгчид хамтран ашиглаж буй сүлжээ, дэд бүтцийн ашиглалт үйлчилгээ болон аливаа хэмжилт, шалгалтыг хийх, тэдгээрийг гүйцэтгэх боломжоор хангах тухай хоёр тал харилцан тохиролцож гэрээндээ тусгана.
- 2.13 Талууд өрсөлдөөний эсрэг аливаа үйлдэл гаргахгүйгээр шударга өрсөлдөх зарчмыг баримтална.
- 2.14 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн эзэмшлийн мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцээ Монгол Улсад бүртгэлгүй өөр улсын үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ашиглах тохиолдолд тус хороонд тухай бүр мэдэгдэнэ.

## **ГУРАВ. МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙГ ХАМТРАН АШИГЛАХ ЖУРАМД ХАМААРАХ ДЭД БҮТЭЦ**

- 3.1 Инженерийн барилга байгууламж
- 3.2 Шон багана
- 3.3 Худаг, сувагчлал
- 3.4 Хуваарилах шүүгээ, хайрцаг
- 3.5 Цамхаг
- 3.6 Сайт
- 3.7 Эрчим хүчний эх үүсвэр
- 3.8 Агааржуулалтын систем
- 3.9 Дохиолол хамгаалалтын систем
- 3.10 Байр талбай, зогсвор
- 3.11 Тоон суваг
- 3.12 Хэрэглэгчийн сүлжээ<sup>1</sup>
- 3.13 Дамжуулах сүлжээний тоног төхөөрөмж болон түүний элемент

### **4 ДӨРӨВ. ИНЖЕНЕРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, БАЙР ТАЛБАЙ, ЦАМХАГ ХАМТРАН АШИГЛАХ**

- 4.1 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн сүлжээний элементийн аюулгүй байдлыг хангах, бусад үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний элементийн аюулгүй байдал, нууцлалыг хадгалах зорилгоор өөрийн байр талбайд нэвтрэн орж ашиглалт үйлчилгээ, хэмжилт шалгалт хийх зэрэг үйл ажиллагааг зохицуулсан аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглана.
- 4.2 Үйлчилгээ эрхлэгч нь стандартын шаардлага хангасан агааржуулалтын систем, галын болон хамгаалалтын дохиоллын систем, гэрэлтүүлэг, зай тэжээлээр хангагдсан байр талбайг бусад үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ашиглана.
- 4.3 Энэ журмын 4.2-д заасан шаардлагыг хангахыг дэд бүтэц хамтран ашиглагч нь үйлчилгээ эрхлэгчээс шаардах эрхтэй.

---

<sup>1</sup> ХХЗХ-ны 2013 оны 26 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Мэдээлэл, холбооны сүлжээний зохицуулалт”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3-г тодорхойлсон.

- 4.4 Үйлчилгээ эрхлэгч нь байр талбайг түүн дэх зай тэжээл, агааржуулалтын болон галын, хамгаалалтын дохиоллын системийн хамт түрээслэн ашиглаж болно.
- 4.5 Үйлчилгээ эрхлэгч нь түрээслэж буй байр талбай, түүнд байрлах тоног төхөөрөмжийн найдвартай, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
- 4.6 Үйлчилгээ эрхлэгч нь байр талбайд байршуулсан бусдын болон өөрийн төхөөрөмж, байр талбайн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангахыг дэд бүтцийг хамтран ашиглаж буй үйлчилгээ эрхлэгчээс шаардах эрхтэй.
- 4.7 Дэд бүтцийг хамтран ашиглагч нь үйлчилгээ эрхлэгчийн байр талбайд өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, зогсвор байрлуулсан тохиолдолд түүний аюулгүй байдлыг хангаж цоож түгжээгээр ханган ажиллана. Цоож түгжээ хийгээгүйгээс үүсэх аливаа асуудлыг үйлчилгээ эрхлэгч хариуцахгүй.
- 4.8 Дэд бүтцийг хамтран ашиглагч нь үйлчилгээ эрхлэгчийн байр талбайг ашиглахдаа байр талбайд хохирол учруулахгүй байх, барилга байгууламжийн өнгө үзэмжийг гэмтээхгүй байх үүрэгтэй.
- 4.9 Дэд бүтцийг хамтран ашиглагч нь үйлчилгээ эрхлэгчийн байр талбайд нэвтэрч ашиглалт үйлчилгээ эрхлэх тохиолдолд бусад үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний элементэд гэмтэл саатал учруулахгүй байж үйлчилгээ эрхлэгчийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажиллана.
- 4.10 Үйлчилгээ эрхлэгч нь байр талбайдаа засвар үйлчилгээ эрхлэх, зарим тоног төхөөрөмжийг нүүлгэх зэрэг үйл ажиллагаа явуулах тохиолдолд тухайн байр талбайг хамтран ашиглаж буй үйлчилгээ эрхлэгчдэд урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
- 4.11 Дэд бүтэц хамтран ашиглагч нь хамтран ашиглаж буй байр талбайдаа техник тоног төхөөрөмжийн суурилуулалт, өргөтгөл хийх тухай бүрдээ үйлчилгээ эрхлэгчдэд урьдчилан мэдэгдэнэ.

## **5 ТАВ. МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХАМТРАН АШИГЛАХ**

- 5.1 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн эзэмшлийн сүлжээний кабель, тоног төхөөрөмжийн интерфейс, хот хоорондын мэдээлэл холбооны сүлжээний урсгал, хэрэглэгчийн сүлжээ зэрэг дэд бүтцийг бусад үйлчилгээ эрхлэгчтэй хэсэгчлэн болон бүтнээр нь хамтран ашиглаж болно.
- 5.2 Үйлчилгээ эрхлэгчид сүлжээний найдвартай байдлыг хангах, харилцан нөөц үүсгэх зорилгоор хамтран ажиллана.
- 5.3 Үйлчилгээ эрхлэгчид нь мэдээлэл холбооны сүлжээний тоног төхөөрөмжийг хамтран ашиглахаар харилцан холболт хийх тохиолдолд нэмэлт хөрөнгө оруулалт хийх шаардлага гарвал үйлчилгээ эрхлэгчид харилцан тохиролцож гэрээндээ тусгана.

## **6 ЗУРГАА. ХҮСЭЛТ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ**

- 6.1 Дэд бүтцийг хамтран ашиглах сонирхолтой үйлчилгээ эрхлэгч нь сүлжээ, сүлжээний элемент, дэд бүтцийг хамтран ашиглах тухай хүсэлтээ үйлчилгээ эрхлэгчид бичгээр гаргана.
- 6.2 Хүсэлтийг үйлчилгээ эрхлэгч хүлээн авч уг хүсэлт нь өөрийн сүлжээний техникийн нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэх, өөрийн сүлжээнд холбох боломжтой эсэх талаар судлаж, хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт бичгээр хариу өгнө.
- 6.2.1 Татгалзсан хариу өгсөн тохиолдолд хариу бичигтээ шалтгааныг тодорхой заана.
- 6.2.2 Зөвшөөрсөн тохиолдолд хариу бичигтээ техник төхөөрөмжийг суурилуулах, холболт хийх, гэрээ байгуулах хугацааны талаар тусгах ба нийт хугацаа ажлын 60 хоногоос хэтрэхгүй байна.
- 6.2.3 Сүлжээний элементийг хамтран ашиглах тохиолдолд зааглах цэгийг талууд гэрээ байгуулахаас өмнө сүлжээ хоорондын зааглах цэгийг заавал тогтоосон байна.
- 6.3 Үйлчилгээ эрхлэгч нь дараах тохиолдолд мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг хамтран ашиглахаас татгалзана. Үүнд:
- 6.3.1 Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтэц түүний элемент нь нөөц гэж тодорхойлогдсон;
- 6.3.2 Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтэц нь бүрэн хэмжээний ашиглалттай;
- 6.3.3 Эхэнд хүсэлт гаргасан үйлчилгээ эрхлэгчдийн хүсэлтийг хүлээн авсан;
- 6.3.4 Үйлчилгээний чанар, хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц гэж үзсэн;
- 6.3.5 Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг өмнө нь хамтран ашиглахдаа байгуулсан гэрээ, гэрээний нөхцөлийн зөрчилтэй.

## **7 ДОЛОО. ҮНЭ ТОГТООХ ЗАРЧИМ**

- 7.1 Үйлчилгээ эрхлэгч нь инженерийн зориулалттай дэд бүтцийн хамтран ашиглах үнэ тарифыг тогтоохдоо Зохицуулах хорооноос баталсан үнэ тариф тогтоох зөвлөмж, аргачлалыг баримтална.
- 7.2 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн эзэмшлийн мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг хамтран ашиглахдаа үнийн ялгаваргүй, нээлттэй, ил тод байх зарчмыг баримтална.

## **8 НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ БОЛОН ХАРИУЦЛАГА**

- 8.1 Энэхүү журмыг зөрчсөн маргаантай асуудлыг маргалдагч талууд шат шатандаа шийдвэрлэхийг оролдох бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа

холбооны тухай хуулийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.

8.2 Маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

8.3 Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар гаргах шийдвэрийнхээ тухай урьдчилан талуудад танилцуулж саналыг нь авах, нээлттэй хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх зэргээр ил тод зарчмыг баримтална.

8.4 Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг үйлчилгээ эрхлэгчид эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд хандаж болно.

8.5 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авна. Үүнд:

8.5.1 Зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх;

8.5.2 Захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх;

8.5.3 Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах;

8.5.4 Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх;

8.5.5 Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох;

8.5.6 Гаргасан зөрчил, зөрчлийг арилгуулахаар авсан арга хэмжээний талаар нийтэд мэдээлэх.

– о О о –

2014 оны 52 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

*Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2013 оны 26 дугаар тогтоолын  
хавсралт*

## **МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ**

**(2014 оны 52 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан)**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү баримт бичгээр Монгол Улсад мэдээлэл, холбооны сүлжээ байгуулахад баримтлах чиглэл, зохицуулалтын үндсэн зарчим, сүлжээний бүтцийг тодорхойлно.

1.2 Зохицуулалтын зорилго нь энэ чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх буюу сүлжээг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг

нэмэгдүүлэх, өрсөлдөөний таатай орчинг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны оновчтой тогтолцоог бий болгоход чиглэнэ.

- 1.3 Энэхүү баримт бичиг нь зөвхөн нийтийн үйлчилгээний мэдээлэл, холбооны сүлжээний зохицуулалтанд хамаарах бөгөөд шуудангийн сүлжээ нь тусдаа баримт бичгээр зохицуулагдана.
- 1.4 Тусгай хэрэглээний сүлжээг Засгийн газраас баталсан “Тусгай хэрэглээний харилцаа холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам”-аар, дотоод хэрэглээний сүлжээ нь энэ баримт бичгээс тусдаа баримт бичгээр зохицуулагдана.
- 1.5 “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2, 3.6-д заасан холбогдох чиглэлийг баримтална.

### **Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт**

- 2.1 “Мэдээлэл, холбооны сүлжээ” гэж мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад хэрэглэх утастай болон утасгүй мэдээлэл холбооны технологи ашигласан дэд бүтэц, кабель шугам, техник төхөөрөмжийн иж бүрдлийг хэлнэ.
- 2.2 “Зангилаа цэг” гэж сүлжээний аюулгүй байдал, тогтвортой найдвартай ажиллагааг хангах өгөгдлийн холболтын тоног төхөөрөмж, технологийн зай тэжээлийн систем, барилга байгууламж бүхий холболтын болон дахин хуваарилалтын цэгийг ойлгоно.
- 2.3 “Сүлжээний үйлчилгээ” гэж мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулж, түрээслүүлэх үйлчилгээ явуулж байгаа бизнесийн үйл ажиллагааг хэлнэ.
- 2.4 “Хот, суурин газар” гэж хот, аймгийн төв, сумын төв, суурин газрыг ойлгоно.
- 2.5 “Нөөц холболт” гэж зангилаа цэг дээрх үндсэн сүлжээний эхлэл төгсгөлийн цэгтэй давхцсан боловч чиглэлийн хувьд ялгаатай, үндсэн сүлжээтэй солбилцолгүйгээр байгуулсан сүлжээг ойлгоно.
- 2.6 “Мэдээлэл, холбооны сүлжээний дэд бүтэц” гэж сүлжээний худаг, сувагчлал, цамхаг, агаарын багана, барилга байгууламжийг ойлгоно.

### **Гурав. Сүлжээний бүтэц, ерөнхий ойлголт**

- 3.1 Сүлжээг зориулалтын хувьд нийтийн үйлчилгээний, тусгай хэрэглээний, дотоод сүлжээ гэж ангилна.
  - 3.1.1 “Нийтийн үйлчилгээний сүлжээ” гэж аж ахуйн нэгж байгууллага, хэрэглэгчдэд мэдээлэл холбооны үйлчилгээг үзүүлэх, бизнес зорилгоор байгуулсан сүлжээг ойлгоно.
  - 3.1.2 “Тусгай хэрэглээний сүлжээ” гэж тусгай зориулалтын холбоо болон төрийн холбооны хэрэгцээнд зориулан байгуулсан үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан, мэдээллийн бүрэн бүтэн хүртээмжтэй байдлыг хангасан, нууцлалын технологи ашигласан харилцаа холбооны сүлжээг ойлгоно.



- 3.1.3 “Дотоод сүлжээ” гэж аж ахуйн нэгж байгууллагын дотооддоо ашиглах зорилгоор байгуулсан, зөвхөн тухайн байгууллагын дотоод мэдээлэл дамжуулах сүлжээг ойлгоно.
- 3.2 Сүлжээг бүтцийн хувьд суурь, түгээх, хэрэглэгчийн сүлжээ гэж ангилна.(Хавсралт 1)
- 3.2.1 “Суурь сүлжээ” (Core) гэж сүлжээний үндсэн зангилаа цэгүүдийг холбосон, их багтаамж, хурд бүхий өргөн зурвасын сүлжээний хэсгийг ойлгоно. (Тухайлбал хот, аймгийн төвүүдийг холбосон сүлжээ)
- 3.2.2 “Түгээх сүлжээ” (Distribution) гэж суурь сүлжээнээс салбарлуулан хэрэглэгчийн сүлжээ хүртэл байгуулсан сүлжээг ойлгоно. (Тухайлбал аймгийн төвөөс сум, суурин газар луу байгуулсан сүлжээ)
- 3.2.3 “Хэрэглэгчийн сүлжээ” (Access) гэж түгээх сүлжээнээс салбарлуулан байгуулсан эцсийн хэрэглэгч хүртэлх сүлжээ болон тэдгээр доторх сүлжээг ойлгоно.
- 3.3 Сүлжээг хамрах хүрээний хувьд улс хоорондын, хот хоорондын, хот суурин газрын сүлжээ гэж ангилна.
- 3.3.1 Улс хоорондын сүлжээ гэж хил дамжин үзүүлж буй олон улсын яриа, транзит урсгал, интернэтийн бөөний үйлчилгээ зэрэг улс хоорондын үйлчилгээ явуулахад зориулсан гадаад улсын сүлжээтэй холбогдсон суурь сүлжээг ойлгоно.
- 3.3.2 Хот хоорондын сүлжээ гэж хот, аймгийн төв, зарим томоохон сумдыг холбосон өргөн зурвасын суурь болон түгээх сүлжээг ойлгоно.
- 3.3.3 Хот суурин газрын сүлжээ гэж хот, аймгийн төв, сумын төв, суурин газрын дотор байгуулсан сүлжээг ойлгоно. Хот суурин газрын сүлжээ нь суурь, түгээх, хэрэглэгчийн сүлжээ хэлбэрээр байж болно.
- 3.4 Мэдээлэл, холбооны нийтийн үйлчилгээнд зориулсан өмчийн бүх төрлийн хэлбэрийн улс, хот хоорондын сүлжээг **үндсэн сүлжээ** гэнэ.

### **Дөрөв. Тусгай зөвшөөрөл**

- 4.1 Мэдээлэл, холбооны нийтийн үйлчилгээний сүлжээ байгуулахад Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгоно.
- 4.2 Мэдээлэл, холбооны үндсэн болон хот суурин газрын сүлжээ байгуулах этгээдэд “А” ангиллын тусгай зөвшөөрлийг 3.3-т заасан төрлийн дагуу олгоно.
- 4.3 “А” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвхөн сүлжээний үйлчилгээ эрхлэх ба “Б” ангиллын үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшихгүй.

- 4.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сүлжээ байгуулахад утасгүй технологи ашиглах тохиолдолд Зохицуулах хорооноос холбогдох журмын дагуу радио давтамжийн тусгай зөвшөөрөл нэмж авна.

### **Тав.Сүлжээний зохицуулалтын үндсэн зарчим**

- 5.1 Яриа, интернэт (өгөгдөл), телевиз радиогийн олон суваг дамжуулах “Б” ангиллын үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь:

5.1.1 Сүлжээний үйлчилгээ эрхлэх зорилгоор мэдээлэл, холбооны сүлжээ байгуулахгүй бөгөөд “А” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс түрээслэнэ.

5.1.2 Зөвхөн өөрийн үйлчилгээгээ хүргэх зорилгоор хот суурин газрын сүлжээ байгуулж болно.

5.1.3 Үүрэн холбооны “Б” ангиллын үйлчилгээ эрхлэгчид үр ашиггүй хөрөнгө оруулалтыг багасгах, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор зөвхөн үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэх “Б” ангиллын үйлчилгээ эрхлэгчтэй дэд бүтцийг хамтран ашиглаж болно.

*/2014 оны хорооны хуралдааны 52 тоот тогтоолоор шинээр нэмсэн/*

- 5.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь шинээр мэдээлэл, холбооны үндсэн сүлжээ байгуулах, өргөтгөх тухай бүрдээ Зохицуулах хороонд доорх бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлж, зөвшөөрөл авна.

5.2.1 Хүсэлт (албан тоот);

5.2.2 Сүлжээг шинээр байгуулах болон өргөтгөх зорилго, үндэслэл;

5.2.3 Шинээр байгуулах, өргөтгөх сүлжээний зураглалыг нөхцөл шаардлагын дагуу газрын зураг болон хүснэгт хэлбэрээр; (цаасан болон файлаар тус бүр нэг хувь)

- 5.3 Шинээр мэдээлэл, холбооны үндсэн сүлжээ байгуулах, өргөтгөх хүсэлтийг үнэлэхдээ дараах шалгуур нөхцлүүдийн дагуу хянана.

5.3.1 Харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого болон бусад холбогдох хууль, тогтоомж, шийдвэрт нийцэж байгаа байдал;

5.3.2 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, түүнтэй холбоотой тогтоол шийдвэр, мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангаж байгаа байдал;

5.3.3 Төрийн өмчит болон хувийн өмчит үндсэн сүлжээтэй үр ашиггүй давхардал үүсэх байдал;

5.3.4 Шинэ дэвшилтэт технологи, олон улсын стандартад нийцсэн байдал;

- 5.3.5 Сүлжээ нь техник технологи, хүний нөөц, ашиглалт үйлчилгээний хувьд найдвартай ажиллагааг бүрэн хангах байдал;
  - 5.3.6 Зах зээлийн өрсөлдөөнд нөлөө үзүүлэх байдал;
  - 5.3.7 Салбарын эдийн засаг болон хэрэглэгчдэд үзүүлэх үр өгөөж.
- 5.4 Сүлжээ байгуулах, өргөтгөх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногт багтаан шалгуур нөхцлийн дагуу үнэлж, үл ялгаварлах, шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэнэ.
- 5.5 Нөөц холболт үүсгэхээс бусад дараах тохиолдолд сүлжээний давхардал үүссэн гэж үзнэ.
- 5.5.1 Нэг чиглэлийн хувьд давхцсан;
  - 5.5.2 Хот суурин газар луу зэрэгцүүлэн хүргэсэн;
  - 5.5.3 Багтаамж хүртээмжтэй байхад давхардуулан байгуулсан.
- 5.6 Зохицуулах хороо мэдээлэл, холбооны сүлжээний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.
- 5.7 Сүлжээ хоорондын холболт, хамтын ажиллагаа**
- 5.7.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос баталсан ”Харилцаа холбооны сүлжээ, инженерийн барилга байгууламжийг хэсэгчлэн түрээслүүлэх журам”-ыг үйл ажиллагаандаа баримтлана.
  - 5.7.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор дэд бүтцийг хамтран ашиглах боломжтой байна.
  - 5.7.3 “А” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчид үндсэн сүлжээг нөөц буюу тойруу (backup) холболттой байхаар байгуулна. Нөөц сүлжээг бусад үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран зохион байгуулж болно.
  - 5.7.4 “А” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сүлжээний үйлчилгээ үзүүлэхдээ нээлттэй байх зарчим баримтлана. Үйлчилгээний үнэ тариф, түрээсийн нөхцөл шаардлага, сүлжээ түрээслүүлэх журмыг (RUO, RLO буюу Reference unbundling offer, Reference leased line offer) боловсруулж, батлан ил тод байлгана.
- 5.8 Үнэ тариф**
- 5.8.1 Зохицуулах хороо зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгох, түүнийг зохицуулах үүргийн дагуу давамгайлал үйлчлэгчийн үнэ тарифыг хянаж, батална.

5.8.2 Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийн гэрээгээр үүрэг хүлээлгэх хэлбэрээр үнэ тарифыг хянаж болно.

5.8.3 Зохицуулах хороо сүлжээний үйлчилгээний үнэ тариф тогтоох аргачлал, зөвлөмжийг гаргаж, хэрэгжүүлнэ.

## 5.9 Хяналт

5.9.1 Зохицуулах хороо нь сүлжээний чанарын үзүүлэлтүүдийг тогтоож, журмын дагуу байнгын хяналт тавьж ажиллана.

5.9.2 Зохицуулах хороо жил бүр хяналтын үр дүнгийн тайлан гаргаж, үйлчилгээ эрхлэгчдэд мэдээлнэ.

5.9.3 Зохицуулах хороо нь сүлжээ байгуулж байгаа үйлчилгээ эрхлэгчидтэй зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор сүлжээг байгуулах төлөвлөгөө, хугацаа, хэрэгжилт, эдийн засгийн хариуцлага хүлээлгэх асуудлуудыг шийдвэрлэж, шийдвэрийг тусгасан гэрээ байгуулна.

5.9.4 Энэхүү зохицуулалтын 5.9.3-т заасан гэрээг зөрчсөн тохиолдолд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## Зургаа. Бусад

6.1 Монгол Улсад онц байдал зарласан, гамшгийн нөхцөл байдал үүссэн үед тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь дараах үүрэгтэй байна.

6.1.1 Сүлжээгээ сэргээх төлөвлөгөөтэй байх;

6.1.2 Гамшгийн үед нөөц сүлжээ зохион байгуулах;

6.1.3 Гамшгийн үед зарлан мэдээлэх үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх;

6.1.4 Онц байдал зарласан үед сүлжээгээ ашиглуулах.

6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гамшгаас хамгаалах мэдээлэл, харилцаа холбооны улсын албанаас гаргасан төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж ажиллана.

– о О о –

Мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц

